

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аддиктологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/047/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: info@bcauditllc.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025-02-25 № 295
танай _____-ны № _____-т

АДДИКТОЛОГИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.ГАНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Аддиктологийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Уламжлалт анагаах ухааны хүрээлэнгийн эрдэмтэн докторуудтай хамтран “Алкуремон” архинд донтох эмгэгийн дуршил бууруулах уламжлалт эмийн клиник судалгаа, Уламжлалт анагаах эмчилгээний төрөлд “Тэргүүн байр” эзэлж, 2 дахь бүтээл болох “Дуудлага” цахим аппликешн нь шилдэг 25 бүтээлд шалгарч шилдэг бүтээлийн “Гэрчилгээ” гардан авсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төвөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	334,211,198.08	559,499,680.04
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	334,211,198.08	559,499,680.04
<u>АВЛАГА</u>	383,672,848.00	56,284,991.10
Ажиллагчидтай холбогдсон авлага		563,131.09
Төлбөртэй үйлчилгээний авлага	383,672,848.00	54,907,760.01
Бусад авлага		814,100.00
<u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u>	75,600,000.00	-
Урьдчилж гарсан зардал	75,600,000.00	
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	275,974,166.71	238,141,401.66
Түүхий эд материал	156,254,071.59	94,824,281.45
Тусгай зориулалтын материал	124,032,413.53	40,016,262.50
Эм боох материал	32,221,658.06	54,808,018.95
Бэлэн бүтээгдэхүүн	50,883,267.11	45,803,267.11
Хангамжийн материал	68,836,828.01	97,513,853.10
Бичиг хэрэг	2,675,790.00	1,735,490.00
Аж ахуйн материал	1,255,940.00	1,187,150.00
Хүнсний материал	7,982,350.00	9,915,450.00
Бусад хангамжийн материал	54,773,006.00	83,839,563.00
Түлш, шатах тослох материал	2,149,742.01	836,200.10
<u>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</u>		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,069,458,212.79	853,926,072.80
<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</u>		
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	544,276,552.05	589,047,353.74
<u>Биет хөрөнгө</u>	404,572,552.05	449,343,353.74
Авто- тээврийн хэрэгсэл	49,000,000.00	49,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(49,000,000.00)	(49,000,000.00)
Машин, тоног төхөөрөмж	777,927,294.51	916,264,341.51
Хуримтлагдсан элэгдэл	(445,023,620.63)	(548,516,954.13)
Тавилга, аж ахуйн эд хогшил	123,516,708.00	143,790,568.00
Хуримтлагдсан элэгдэл	(53,717,029.83)	(64,063,801.64)
Бусад үндсэн хөрөнгө	5,219,200.00	5,219,200.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,350,000.00)	(3,350,000.00)
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	139,704,000.00	139,704,000.00
Программ хангамж	1,000,000.00	1,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,000,000.00)	(1,000,000.00)
Бусад	139,704,000.00	139,704,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	544,276,552.05	589,047,353.74
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,613,734,764.84	1,442,973,426.54
Өглөг	76,996,735.55	8,662,688.47
Ажиллагчидтай холбогдсон өглөг	9,606,713.26	2,423,974.01

**АДДИКТОЛОГИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Бараа үйлчилгээний зардлын өглөг	65,516,437.28	4,368,916.08
Бусад өглөг	1,873,585.01	1,869,798.38
Байгууллагад төлөх өглөг	708,214.01	1,499,298.38
Хувь хүмүүст төлөх өглөг	1,165,371.00	370,500.00
Урьдчилж орсон орлого	-	-
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	76,996,735.55	8,662,688.47
<u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	76,996,735.55	8,662,688.47
Засгийн газрын хувь оролцоо	1,536,738,029.29	1,434,310,738.07
Засгийн газрын оруулсан капитал	311,085,717.60	311,085,717.60
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	311,085,717.60	311,085,717.60
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,840,708.33	2,840,708.33
Хуримтлагдсан үр дүн	1,222,811,603.36	1,120,384,312.14
Өмнөх үеийн үр дүн	1,222,811,603.36	1,223,376,974.36
Тайлан үеийн үр дүн		(102,992,662.22)
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>	1,536,738,029.29	1,434,310,738.07
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>	1,613,734,764.84	1,442,973,426.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	4,735,067,074.00	3,137,725,352.00
Улсын төсвөөс	447,900,000.00	-
Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	447,900,000.00	
Төсвийн захирагчдаас	920,613,000.00	
Төсвийн ерөнхийлөн захирагчдаас олгосон санхүүжилт	920,613,000.00	
Бусад төсөвт байгууллагаас	58,823,170.00	
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,307,730,904.00	3,137,725,352.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,307,730,904.00	3,137,725,352.00
Бараа, үйлчилгээний орлого	806,213,268.30	446,149,228.14
Төсөвт байгууллагын өөрийн орлого	211,277,300.00	312,226,726.14
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	197,696,300.00	228,704,144.00
Туслах үйл ажиллагааны орлого	13,581,000.00	83,522,582.14
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	76,880,235.30	109,715,002.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	2,055,733.00	
Бусад орлого	516,000,000.00	24,207,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,541,280,342.30	3,583,874,580.14
<u>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	2,017,189,694.74	2,654,955,798.78
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,800,575,892.15	2,374,524,017.96
Цалин	957,341,131.10	1,132,244,344.82

**АДДИКТОЛОГИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Цалингийн тусгай нэмэгдлүүд	614,289,751.05	903,363,285.14
Унаа хоолны хөнгөлөлт	116,230,000.00	164,026,000.00
Урамшуулал	112,715,010.00	174,890,388.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	216,613,802.59	280,431,780.82
Тэтгэврийн даатгал	150,309,404.25	193,450,683.39
Тэтгэмжийн даатгал	17,910,116.72	25,044,365.31
ҮОМШӨ-ний даатгал	8,939,466.82	11,784,604.43
Эрүүл мэндийн даатгал	31,643,034.38	40,383,707.61
Ажилгүйдлын даатгал	7,811,780.42	9,768,420.08
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>	2,218,584,711.48	941,538,861.44
Үйл ажиллагааны зардал	2,218,584,711.48	941,538,861.44
Хоол	349,700,826.00	157,691,748.00
Эм	407,796,698.04	371,810,070.06
Бусад бараа үйлчилгээний зардал	5,350,000.00	
Бичиг хэргийн материал	14,636,520.00	9,768,510.00
Тээвэр, шатахууны зардал	13,920,186.00	4,813,526.28
Шуудан холбооны зардал	9,452,046.42	8,647,798.91
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,972,967.40	15,437,664.08
БҮТЭЗ	73,589,266.00	39,543,963.00
Ном, хэвлэлийн зардал		669,500.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	19,061,650.00	18,080,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		5,080,000.00
Газрын төлбөр	693,822.00	693,820.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	599,144,553.16	50,293,378.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,500,000.00
Урсгал засварын зардал	8,593,500.00	8,600,400.00
Багаж, техник, хэрэгсэл	798,000.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,173,137.50	22,392,521.80
Байрны түрээсийн зардал	591,400,000.00	75,600,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	37,752.00	107,856.00
Холбооны суваг ашигласны зардал	12,283,100.00	33,968,000.00
Элэгдлийн зардал	83,980,686.96	113,840,105.31
Урсгал шилжүүлэг	107,056,677.00	90,372,582.14
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,823,170.00	83,522,582.14
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	5,280,000.00	6,850,000.00
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	42,953,507.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,342,831,083.22	3,686,867,242.36
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,198,449,259.08	(102,992,662.22)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,198,449,259.08	(102,992,662.22)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	4,382,591,056.00	3,466,490,439.99
Улсын төсвөөс	447,900,000.00	-
Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	447,900,000.00	
Орон нутгийн төсвөөс	920,613,000.00	-
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	920,613,000.00	
Нийгмийн даатгалын сангаас	3,014,078,056.00	3,466,490,439.99
Эрүүл мэндийн даатгалын сангаас	3,014,078,056.00	3,466,490,439.99
Бараа, үйлчилгээний орлого	211,277,300.00	336,434,226.14
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	197,696,300.00	228,704,144.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,581,000.00	83,522,582.14
Бусад орлого	516,000,000.00	24,207,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,109,868,356.00	3,802,924,666.13
Ажиллагчидтай холбогдсон зардал	2,235,748,935.35	2,662,701,669.12
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,716,531,993.97	2,372,429,137.33
Цалин	887,631,666.96	1,131,788,299.46
Цалингийн тусгай нэмэгдлүүд	603,221,564.22	902,311,909.83
Унаа хоолны хөнгөлөлт	114,462,563.63	163,618,633.73
Урамшуулал	111,216,199.16	174,710,294.31
Нийгмийн хамгааллын шимтгэл	519,216,941.38	290,272,531.79
Тэтгэврийн даатгал	471,179,319.80	205,320,374.46
Тэтгэмжийн даатгал	12,957,625.17	23,053,505.31
ҮОМШӨ-ний даатгал	6,425,110.03	11,784,603.83
Ажилгүйдлийн даатгал	5,670,805.94	9,768,420.08
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,984,080.44	40,345,628.11
Бараа, үйлчилгээний урсгал зардал	2,334,825,110.22	775,666,027.91
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	869,496,969.00	557,403,195.00
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	517,685,149.00	391,548,397.00
Хоол, хүнс	351,811,820.00	165,854,798.00
Бусад бараа үйлчилгээний зардал	1,465,328,141.22	218,262,832.91
Бичиг хэргийн материал	14,428,780.00	8,351,610.00
Тээвэр, шатахууны зардал	15,790,600.00	3,892,600.00
Шуудан холбооны зардал	10,300,246.42	8,779,498.91
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,686,240.00	12,450,240.00
БҮТЭЗ	64,874,640.00	34,707,250.00
Ном, хэвлэлийн зардал	5,500,000.00	16,166,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	19,386,490.00	4,539,980.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	19,783,012.00	18,080,000.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	13,699,500.00	10,839,000.00
Багаж техник хэрэгсэл	710,000.00	550,000.00
Урсгал засварын зардал	6,090,843.00	10,187,900.00

**АДДИКТОЛОГИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	599,616,615.80	49,953,378.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,500,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	37,752.00	107,856.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,729,600.00	34,463,000.00
Газрын төлбөр	693,822.00	693,820.00
Байрны түрээсийн зардал	667,000,000.00	
Урсгал шилжүүлэг	48,233,507.00	90,372,582.14
Олон улсын байгууллагын гишүүний татвар		
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		83,522,582.14
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	5,280,000.00	6,850,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	42,953,507.00	-
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	42,953,507.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	4,618,807,552.57	3,528,740,279.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	491,060,803.43	274,184,386.96
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	201,376,600.00	48,895,905.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	201,376,600.00	48,895,905.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(201,376,600.00)	(48,895,905.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	289,684,203.43	225,288,481.96
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		334,211,198.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	334,211,198.08	559,499,680.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	311,085,717.60	2,840,708.38	23,680,489.27	337,606,915.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт,			681,854.96	681,854.96
Залруулсан үлдэгдэл				-
Тайлант үеийн үр дүн			1,198,449,259.08	1,198,449,259.08
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	311,085,717.60	2,840,708.33	1,222,811,603.36	1,536,738,029.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			565,371.00	565,371.00
Залруулсан үлдэгдэл				-
Тайлант үеийн үр дүн			102,992,662.22)	(102,992,662.22)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	311,085,717.60	2,840,708.33	1,120,384,312.14	1,434,310,738.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,283,679,700.00	3,466,490,439.99	817,189,260.01	80.9
Нийгмийн даатгалын сангаас	4,283,679,700.00	3,466,490,439.99	817,189,260.01	80.9
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,283,679,700.00	3,466,490,439.99	817,189,260.01	80.9
Бараа, үйлчилгээний орлого	632,367,200.00	336,434,226.14	295,932,973.86	53.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,248,800.00	228,704,144.00	(42,455,344.00)	122.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,907,200.00	83,522,582.14	28,384,617.86	74.6
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	334,211,200.00		334,211,200.00	-
Бусад орлого	35,140,000.00	24,207,500.00	10,932,500.00	68.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,916,046,900.00	3,802,924,666.13	1,113,122,233.87	77.4
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,121,397,200.00	2,662,701,669.12	458,695,530.88	85.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,698,464,300.00	2,372,429,137.33	326,035,162.67	87.9
Цалин	2,068,688,000.00	1,131,788,299.46	936,899,700.54	54.7
Цалингийн тусгай нэмэгдлүүд	410,689,900.00	902,311,909.83	(491,622,009.83)	219.7
Унаа хоолны хөнгөлөлт	109,883,500.00	163,618,633.73	(53,735,133.73)	148.9
Урамшуулал	109,202,900.00	174,710,294.31	(65,507,394.31)	160.0
Нийгмийн хамгааллын шимтгэл	422,932,900.00	290,272,531.79	132,660,368.21	68.6
Тэтгэврийн даатгал	317,881,600.00	205,320,374.46	112,561,225.54	64.6
Тэтгэмжийн даатгал	26,262,800.00	23,053,505.31	3,209,294.69	87.8
ҮОМШӨ-ний даатгал	13,131,400.00	11,784,603.83	1,346,796.17	89.7
Ажилгүйдлийн даатгал	13,131,400.00	9,768,420.08	3,362,979.92	74.4
Эрүүл мэндийн даатгалын хураамж	52,525,700.00	40,345,628.11	12,180,071.89	76.8
Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,697,182,500.00	824,561,932.91	872,620,567.09	48.6
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	1,235,263,200.00	557,403,195.00	677,860,005.00	45.1
Хоол	130,679,500.00	165,854,798.00	(35,175,298.00)	126.9
Эм	1,104,583,700.00	391,548,397.00	713,035,303.00	35.4
Бусад бараа үйлчилгээний зардал	461,919,300.00	267,158,737.91	194,760,562.09	57.8
Бичиг хэргийн материал	11,937,000.00	8,351,610.00	3,585,390.00	70.0
Тээвэр, шатахууны зардал	19,773,200.00	3,892,600.00	15,880,600.00	19.7
Шуудан холбооны зардал	10,541,000.00	8,779,498.91	1,761,501.09	83.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,862,000.00	12,450,240.00	6,411,760.00	66.0
БҮТЭЗ	26,919,500.00	34,707,250.00	(7,787,750.00)	128.9
Ном, хэвлэлийн зардал	18,500,000.00	16,166,700.00	2,333,300.00	87.4

**АДДИКТОЛОГИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	20,111,200.00	18,080,000.00	2,031,200.00	89.9
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	9,247,300.00	10,839,000.00	(1,591,700.00)	117.2
Маягт хэвлүүлэх зардал	500,000.00		500,000.00	-
Багаж, техник хэрэгсэл	57,499,200.00	34,205,405.00	23,293,795.00	59.5
Тавилга	7,810,000.00	15,240,500.00	(7,430,500.00)	195.1
Урсгал засварын зардал	13,900,000.00	10,187,900.00	3,712,100.00	73.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,635,000.00	49,953,378.00	145,681,622.00	25.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,366,900.00	4,500,000.00	3,866,900.00	53.8
Даатгалын үйлчилгээ	330,000.00		330,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	175,000.00	107,856.00	67,144.00	61.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00		100,000.00	-
Газрын төлбөр	848,000.00	693,820.00	154,180.00	81.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,624,000.00	34,463,000.00	1,161,000.00	96.7
Бараа үйлчилгээний бусад зардал	5,240,000.00	4,539,980.00	700,020.00	86.6
Урсгал зардлын дүн	132,607,200.00	90,372,582.14	42,234,617.86	68.2
Бусад урсгал шилжүүлэг	132,607,200.00	90,372,582.14	42,234,617.86	68.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	118,107,200.00	83,522,582.14	34,584,617.86	70.7
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	14,500,000.00	6,850,000.00	7,650,000.00	47.2
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,951,186,900.00	3,577,636,184.17	1,373,550,715.83	72.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		334,211,198.08		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		559,499,680.04		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,763.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2,603.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 28,159.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Төлбөрийн акт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хог тээврийн үйлчилгээ эрхэлдэггүй байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулж хог хаягдлын үйлчилгээний хураамж төлсөн байна.	1	2,700.00			1	2,700.00
Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөөгүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	25,459.8			1	25,459.8
Батлагдсан орон тоонд тусгагдаагүй хавсран ажилласны нэмэгдэл мөн ажилд ороод 6 сар болж байгаа ажилтанд биеэр эдлээгүй ээлжийн амралтын мөнгөн олговор олгосон байна.	1	2,603.6	1	2,603.6		
Дүн	3	30,763.38	1	2,603.6	2	28,159.8

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.